# ТЕНДЕРИЙН УРИЛГА

| | |
|---|---|
| **Огноо:** | 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр |
| **Төслийн дугаар, нэр:** | 3072-MON: Төлбөрийн системийн шинэчлэл төсөл |
| **Тендер шалгаруулалтын дугаар, нэр:** | 37: ҮЦГТ-ийн Барилгын Мэдээллийн Технологийн Тоног Төхөөрөмж<br>Багц 1 – ҮЦГТ-ийн барилгын секюрити төхөөрөмжүүд<br>Багц 2 – Оффисын МТ-ийн системүүд<br>Багц 3 – Нөөц цахилгааны эх үүсвэрийн систем |
| **Тендерийн материал ирүүлэх сүүлийн хугацаа:** | 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн Улаанбаатарын цагаар 15:00 цаг |

1. Монгол Улсын Засгийн газар нь Азийн Хөгжлийн Банк (АХБ)-наас Төлбөрийн системийн шинэчлэл төслийг хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан ба энэхүү зээлийн хөрөнгийн тодорхой хэсгийг Үндэсний Цахим Гүйлгээний Төв (ҮЦГТ)-ийн Барилгын Мэдээллийн Технологийн Тоног Төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах гэрээг санхүүжүүлэхэд зарцуулна.

2. Тендерийн баримт бичигт заасны дагуу тендерт оролцогчид нэгээс олон багцад тендер ирүүлж болно. Нэгээс олон гэрээ байгуулсан тохиолдолд хөнгөлөлт үзүүлэхийг хүссэн тендерт оролцогч нь энэхүү хөнгөлөлтийг тендер ирүүлэх маягтад тусгана.

3. Монголбанк эрх бүхий тендерт оролцогчдоос ҮЦГТ-ийн Барилгын Мэдээллийн Технологийн Тоног Төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах зорилгоор битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

4. Дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтыг АХБ-ны нэг шаттай, нэг дугтуйт горимын дагуу явуулах бөгөөд эрх бүхий орны харьяат нийт тендерт оролцогчдод нээлттэй байна.

5. Зөвхөн доорх шаардлагуудыг хангасан тендерт оролцогч оролцох хэрэгтэй:
   - **Жилийн дундаж борлуулалт.** Сүүлийн гурван жилд (2017, 2018, 2019) бараа нийлүүлэх гэрээ гүйцэтгэж дууссан эсхүл гүйцэтгэж байгаа гэрээний жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ нь багц тус бүрээр:
     Багц 1: ҮЦГТ-ийн барилгын секюрити төхөөрөмжүүд – 520 сая төгрөг
     Багц 2: Оффисын МТ-ийн системүүд – 780 сая төгрөг
     Багц 3: Нөөц цахилгааны эх үүсвэрийн систем - 1 тэрбум 200 сая төгрөг
     Хоёр болон түүнээс дээш тооны багцад оролцож буй тохиолдолд дээр дурдсан багцын нийлбэр үнийн дүнгийн шаардлагыг хангасан байна.
   - **Гэрээний туршлага.** Сүүлийн гурван жилд (2017, 2018, 2019) үндсэн гүйцэтгэгчээр амжилттай ажиллаж дууссан 2 (хоёр) гэрээтэй байна. Гэрээ тус бүрийн нийт үнийн дүн нь багц тус бүрээр:
     Багц 1: ҮЦГТ-ийн барилгын секюрити төхөөрөмжүүд – 400 сая төгрөг
     Багц 2: Оффисын МТ-ийн системүүд – 600 сая төгрөг
     Багц 3: Нөөц цахилгааны эх үүсвэрийн систем - 950 сая төгрөг
     Гэрээний агуулга ба бүрдэл нь ижил төстэй тоног төхөөрөмжийг нийлүүлэх гэрээ байх ёстой. Хоёр болон түүнээс дээш тооны багцад оролцож буй тохиолдолд дээр дурдсан багцын нийлбэр үнийн дүнгийн шаардлагыг хангасан байна.
   - **Санхүүгийн байдал.** Сүүлийн гурван жилийн (2017, 2018, 2019) аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан (тайлан баланс, орлогын тайлан)-г үндэслэн тендерт оролцогч урт хугацаанд ашигтай ажиллаж байгааг харуулж чадах санхүүгийн тогтвортой байдал.
   - **Мөнгөн гүйлгээний чадавх.** Гэрээний доод хэмжээ багц тус бүрээр Гэрээний хэрэгжилтийн явцад шаардлагатай мөнгөн гүйлгээний хэрэгцээг хангаж чадах түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, авах боломжтой зээл, эсхүл бусад санхүүжилтийн нийт хэмжээ багц тус бүрээр:
     Багц 1: ҮЦГТ-ийн барилгын секюрити төхөөрөмжүүд – 350 сая төгрөг
     Багц 2: Оффисын МТ-ийн системүүд – 720 сая төгрөг
     Багц 3: Нөөц цахилгааны эх үүсвэрийн систем - 820 сая төгрөг
     Хоёр болон түүнээс дээш тооны багцад оролцож буй тохиолдолд дээр дурдсан багцын нийлбэр үнийн дүнгийн шаардлагыг хангасан байна.
   - **Шүүхийн зарга ба маргаан.** Одоо хянан шийдвэрлэгдэж буй аливаа нэхэмжлэл, шаардлага, арбитрын ажиллагаа, эсхүл бусад төрлийн шүүхийн зарга, маргааны нийт хэмжээ нь тендерт оролцогчийн цэвэр хөрөнгийн 50 (тавин) хувиас илүүгүй байна.

6. Сонирхсон эрх бүхий тендерт оролцогчид нэмэлт мэдээллийг ажлын өдрүүдийн 09:30 - 12:30, 14: 00-17: 00 цагийн хооронд доорхи хаягаар Төлбөрийн систем шинэчлэх төслийн хэрэгжүүлэгч байгууллагаас авах боломжтой.

7. Сонирхсон тендерт оролцогч нь бичгээр хүсэлтээ гаргаж, 300,000 (гурван зуун мянган) төгрөгтэй тэнцэх хураамжийг эргэн үл төлөгдөх нөхцөлтэйгөөр төлсөнөөр Монгол хэл дээр бэлтгэгдсэн тендерийн баримт бичгийг худалдан авч болно. Тендерийн баримт бичгийг худалдан авах эрх бүхий этгээд нь:
   - 37 дугаартай тендерийн баримт бичгийг худалдан авах хүсэлтээ албан бичгээр уг тендерийн урилгад заасан хаягаар ирүүлнэ.
   - Төлбөр хүлээн авах данс:
     Банкны нэр: Төрийн банк
     Дансны дугаар: 109000067145
     Дансны нэр: Төлбөрийн системийн шинэчлэл төсөл
   - Тендерийн баримт бичгийг хүлээн авахаар томилогдсон хүн нь дараах баримт бичгийг авч ирэх ёстой. Үүнд:
     *(i) Компанийн танилцуулга*
     *(ii) Тендерийн баримт бичиг худалдан авах хүсэлт, албан бичиг*
     *(iii) Иргэний үнэмлэх эсвэл паспорт*

8. Тендерийг 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 15:00 цагт эсхүл түүнээс өмнө доорх хаягаар ирүүлнэ. Тендерийн баримт бичигт тусгасны дагуу бүх тендерт дараах үнийн дүнтэй тендерийн баталгаа гаргаж ирүүлнэ. Үүнд:
   (i) Багц 1: ҮЦГТ-ийн барилгын секюрити төхөөрөмжүүд – 12 сая төгрөг,
   (ii) Багц 2: Оффисын МТ-ийн системүүд – 24 сая төгрөг,
   (iii) Багц 3: Нөөц цахилгааны эх үүсвэрийн систем - 28 сая төгрөг.
   Хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахаас татгалзана. Тендерийг 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 15:00 цагт доор заасан хаягаар хүрэлцэн ирж, нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ:
   *Бодь Цамхаг, Жигжиджавын гудамж 3, Чингэлтэй Дүүрэг*
   *Улаанбаатар 15160, Монгол Улс, 1003 тоот, 10 давхар*

9. Тендер бэлтгэх эсхүл хүргэхтэй холбоотойгоор тендерт оролцогчийн зүгээс гаргасан аливаа зардлыг Монголбанк хариуцахгүй.



| | |
|---|---|
| Захиалагч: | Монголбанк |
| Харилцах албан тушаалтан: | Ц.Цог, Төслийн худалдан авалтын мэргэжилтэн |
| Гудамж/байр: | Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамж 3, Бодь цамхаг |
| Давхар/өрөө: | 10-р давхар, 1003 тоот |
| Аймаг/хот: | Улаанбаатар хот |
| Шуудангийн дугаар: | 15160 |
| Улс: | Монгол Улс |
| Цахим шуудан: | **procurement@psmp.mn** |
| Утас: | (976) – 70119910 |
| Факс: | (976) - 11311471 |